



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 527

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 16 нэрийн, нийт 3,189,586,537.98 (гурван тэрбум нэг зуун наян есөн сая таван зуун наян зургаан мянга таван зуун гучин долоон төгрөг ерэн найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, 1,115,744,502.02 (нэг тэрбум нэг зуун арван таван сая долоон зуун дөчин дөрвөн мянга таван зуун хоёр төгрөг хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Үндсэн хөрөнгийг буулгах, нүүлгэн шилжүүлэх, засаж сэлбэн, угсарч суурилуулах, шинэчилж сайжруулах ажлыг зохион байгуулж, холбогдох зардлыг тооцон, данс бүртгэлд тусгахыг “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Тогтохсүрэнд зөвшөөрсүгэй.

3.“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Б.Чагнаадорж, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Тогтохсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

3.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

3.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132002371

23-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн  
 5077 дугаар тогтоолын хавсралт

**"ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН БАЛАНСААС  
 "МОНГОЛРОСЦВЕТМЕТ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал- тад орсон огноо	Хэм- жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Роторт бутлуур-1	2019/12/01	ш	1.00	596,704,115.90	596,704,115.90	209,246,638.67	387,457,477.23
2	Роторт бутлуур-2	2019/12/01	ш	1.00	596,704,115.90	596,704,115.90	209,246,638.67	387,457,477.23
3	Роторт бутлуур-3	2019/12/01	ш	1.00	596,704,115.90	596,704,115.90	209,246,638.67	387,457,477.23
4	Чичиргээт шигшүүр-1	2019/12/01	ш	1.00	238,199,509.91	238,199,509.91	83,529,585.23	154,669,924.68
5	Чичиргээт шигшүүр-2	2019/12/01	ш	1.00	238,199,509.91	238,199,509.91	83,529,585.23	154,669,924.68
6	Ган каркасан суурь /Роторт бутлуур/-1	2019/12/01	ш	1.00	26,512,644.93	26,512,644.93	9,297,206.80	17,215,438.13
7	Ган каркасан суурь /Роторт бутлуур/-2	2019/12/01	ш	1.00	26,512,644.93	26,512,644.93	9,297,206.80	17,215,438.13
8	Конвейр 5,6,7 /В1000*33.5м, 30квт/	2019/12/01	ш	2.00	136,312,447.12	272,624,894.24	95,601,558.76	177,023,335.48
9	Конвейр 10 /В800*30м, 22 квт/	2019/12/01	ш	1.00	90,874,964.76	90,874,964.76	31,867,185.23	59,007,779.53
10	Конвейр 11 /В800*30м, 22 квт/	2019/12/01	ш	1.00	90,874,964.76	90,874,964.76	31,867,185.23	59,007,779.53
11	Конвейр 12 /В800*30м, 22 квт/	2019/12/01	ш	1.00	51,928,551.28	51,928,551.28	18,209,821.01	33,718,730.27
12	Конвейр 13 /В800*30м, 22 квт/	2019/12/01	ш	1.00	51,928,551.28	51,928,551.28	18,209,821.01	33,718,730.27
13	Конвейр 18 /В800*30м, 22 квт/	2019/12/01	ш	1.00	51,928,551.28	51,928,551.28	18,209,821.01	33,718,730.27

14	Дэд өртөө-1 /E-house КТПН/	2019/12/01	ш	1.00	122,057,406.50	122,057,406.50	42,801,953.52	79,255,452.98
15	Дэд өртөө-2 /E-house КТПН/	2019/12/01	ш	1.00	122,057,406.50	122,057,406.50	42,801,953.52	79,255,452.98
16	Гал тогооны сууц АЗТ	2015/11/28	ш	1.00	15,774,590.00	15,774,590.00	2,781,702.66	12,992,887.34
	<b>НИЙТ ДҮН</b>			<b>17.00</b>	<b>3,053,274,090.86</b>	<b>3,189,586,537.98</b> (Гурван тэрбум нэг зуун наян есөн сая таван зуун наян зургаан мянга таван зуун гучин долоон төгрөг ерэн найман мөнгө)	<b>1,115,744,502.02</b> (нэг тэрбум нэг зуун арван таван сая долоон зуун мянга таван зуун хоёр төгрөг хоёр мөнгө)	<b>2,073,842,035.96</b> (хоёр тэрбум далан гурван сая найман зуун дөчин хоёр мянга гучин таван төгрөг ерэн зургаан мөнгө)